

20~~24~~ он 04 сар 19 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

**Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх болон түүнтэй
холбоотой журам батлах, худалдаж авах тухай зөвшөөрөл олгох,
эргүүлэн худалдан авах хувьцааны үнийг тогтоох тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйл, 54 дүгээр зүйл, 55 дугаар зүйлийн 55.2, 55.3, 55.4, 55.7, 76 дугаар зүйлийн 76.1.7, 76.1.17 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Компанийн дурмийн 6.2.7.6, 6.2.7.15 дахь заалт болон “Таван Богд Холдингс” ХХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн №01А-154 тоот дугаартай саналыг тус тус үндэслэн “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Говь” ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч “Таван Богд Холдингс” ХХК-ийн хувьцааны эзэмшил 75 хувийг давсан тул бусад хувьцаа эзэмшигчид хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хавсралтаар батлагдсан журмын дагуу хэрэгжүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. “Говь” ХК-ийн бусад хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх журам /“Говь” ХК-ийн хувьцааг худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэх журам/-ыг Хавсралт 1 ёсоор баталсугай.
3. Нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах зах зээлийн үнийг хараат бус үнэлгээний байгууллага болох “Далайван Проперти Үнэлгээ” ХХК-аас гаргасан үнэлгээний тайлан, хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш, зах зээлийн ханшийг харгалзан 268.26 /хоёр зуун жаран найман төгрөг хорин зургаан мөнгө/ төгрөг байхаар тогтоосугай.
4. Энэхүү тогтоолд заасан үнэ, журмын дагуу худалдан авахыг хяналтын багцын хувьцааг эзэмшигч “Таван Богд Холдингс” ХХК-д зөвшөөрсүгэй.
5. Өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах өдрийг уг эрх үүссэн өдөр буюу 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөр тогтоосугай.
6. Энэхүү шийдвэрийн талаарх мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржид 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хүргүүлэн, хувьцаа эзэмшигчдэд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу 2024 оны 04 дүгээр сарын 24-ний болон 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлан мэдэгдсүгэй.
7. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг Хавсралт 2 ёсоор баталсугай.
8. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хүлээн авах хугацааг олон нийтэд анх мэдэгдсэнээс хойш ажлын

2024 он 04 сар 19 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

30 өдөр буюу 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийг дуустал байхаар тогтоосугай.

9. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг Үнэт цаасны компани болох “Таван Богд Капитал ҮЦК” ХХК болон “Говь” ХК-д бичгээр цаасан болон цахим хэлбэрээр энэхүү тогтоолын 8-д заасан хугацаанд хүлээн авахаар тогтоосугай.
10. Энэхүү шийдвэрийг сонирхлын зөрчилгүй буюу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталсугай.
11. Энэхүү тогтоолыг болон Хувьцаа эргүүлэн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.
12. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн мэдээллийг хэрэгслээр зар хүргэх журмын дагуу хүргэх, хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх шаардлагыг хүлээн авах, тайлан, мэдээлэл хүргэн ажиллахыг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ХАРААТ БУС ГИШҮҮДДАХ ЗӨВЛӨЛ




Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

Д.ХҮРЭЛБААТАР



“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ШААРДАХ ЭРХИЙН
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Говь” ХК (цаашид “Компани” гэх)-ийн хяналтын багц эзэмшигч болох “Таван Богд Холдингс ХХК”-аас бусад хувьцаа эзэмшигч (цаашид “Бусад хувьцаа эзэмшигч” гэх)-ээс өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах, шаардах эрхээ хэрэгжүүлэх, Компани нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчдээс хувьцааг эргүүлэн худалдан авахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.
 - 1.2 Компанийн хяналтын багц эзэмшигч “Таван Богд Холдингс” ХХК-ийн хувьцаа худалдан авсан өдөр буюу 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийг хувьцаа эзэмшигчдэд Компанид хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрх үүссэнд тооцно.
 - 1.3 Компани хувьцаа эзэмшигчийн шаардлагаар эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (Цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлаас хараат бус үнэлгээний байгууллага болох “Далайван проперти үнэлгээ” ХХК-иас гаргасан үнэлгээний тайлан, хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзан 268.26 төгрөгөөр тогтоосон болно.
 - 1.4 Компани нь энэхүү журмын дагуу хувьцааг эргүүлэн худалдан авах шаардлагыг ируулсэн хувьцаа эзэмшигчийн хувьцааг худалдаж авахыг хяналтын багц эзэмшигч “Таван Богд Холдингс” ХХК-д зөвшөөрсөн болно.

ХОЁР. БУСАД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэгт заасны дагуу бусад энгийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхтэй.
 - 2.2 Бусад хувьцаа эзэмшигчид нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цахим хэлбэрээр анх мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор буюу 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийг дуустал Үнэт цаасны компани болох “Таван Богд Капитал ҮЦК” ХХК болон “Говь” ХК-д өөрийн шаардлагаа бичгээр цаасан хэлбэрээр биечлэн эсвэл цахим хэлбэрээр хүргүүлнэ.
 - 2.3 Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-д заасны дагуу хувьцаагаа эргүүлэн авахыг шаардсан хувьцаа эзэмшигч нь шаардлагадаа эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, эргүүлэн авахыг шаардаж буй хувьцааны тоо,

төрөл, эргэж холбогдох утасны /холбоо/-ны дугаар зэрэг хувийн мэдээллийг ирүүлэхийг зөвшөөрч хавсралтад заагдсан мэдээллийг бүрэн оруулах үүрэгтэй.

- 2.4 Хувьцаа эзэмшигч нь Компанид хувьцаа худалдах тухай шаардлагыг бичгээр гаргахдаа холбогдох мэдээллийг үнэн зөв гаргах үүрэгтэй ба шаардлагад худал мэдээлэл оруулсантай холбогдуулан гарах үр дагаврыг Компани хариуцахгүй болно.

ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Компаниас шаардах эрх үүссэн талаарх шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаартай “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу өдөр тутам хэвлэгдэн гардаг сонин, орон даяар нэвтрүүлэг хүргэдэг телевиз, Компанийн өөрийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар тус бүр 2-оос доошгүй удаагийн давтамжтайгаар буюу 2024 оны 04 дүгээр сарын 24-ний болон 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.
- 3.2 Энэ журмын 2.2-д зааснаар Компанид хүргүүлсэн хувьцаа эзэмшигчийн шаардлагыг хүлээн авч хуульд заасан хугацаанд шийдвэрлэн хариу хүргүүлэх үүрэгтэй.
- 3.3 Хувьцаа эзэмшигч Компанид эргүүлэн худалдах хувьцааны үнийг зах зээлийн үнээс бодит бус, өндөөр үнэлэн шаардах эрхийн хүсэлтийг ирүүлсэн тохиолдолд Компани хувьцааг худалдан авахаас татгалзах эрхтэй.
- 3.4 Компани нь хувьцаа эзэмшигчийн хувийн мэдээллийг хамгаалж бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШААРДЛАГААР КОМПАНИ ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХЫГ ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

- 4.1 Компанийн хяналтын багц эзэмшигч “Таван Богд Холдингс” ХХК-ийн хувьцаа худалдан авсан өдөр буюу 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийг хувьцаа эзэмшигч компанийд хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрх үүссэнд тооцно.
- 4.2 Компани нь хувьцаа эзэмшигчдэд Компанид хувьцаагаа эргүүлэн худалдах эрх үүссэн тухай мэдэгдлийг энэхүү журмын 3.1-т заасны дагуу хүргэнэ.
- 4.3 Компани нь энэ журмын 4.1-д заасан “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тархалтын мэдээнд үндэслэн нэrsийн жагсаалтыг батална.
- 4.4 Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь эргүүлж авах тухай шаардлагыг энэ журмын Хавсралт №1-д заасан маягтын дагуу бичгээр гаргах бөгөөд доорх хаяг руу цаасан хэлбэрээр биечлэн эсвэл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

№	Шаардлага хүлээх авагч	Цаасан хэлбэрээр хүргүүлэх хаяг	Цахим хэлбэрээр хүргүүлэх хаяг
1	“Таван Богд Капитал УЦК” ХХК	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, “Галлериа-Улаанбаатар” худалдаа үйлчилгээний төвийн зүүн жигүүр, 1 давхарт, “Таван Богд Капитал УЦК” ХХК	cr@tavanbogdcapital.com
2	“Говь” ХК	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн тудамж, “Говь” ХК	boardoffice@gobi.mn

- 4.5 Хувьцаа эзэмшигч нь энэ журмын 2.2-д заасны дагуу ажлын 30 өдрийн дотор шаардах эрх хэрэгжүүлэх шаардлагыг (Хавсралт №1-д заасан маягтын дагуу) ирүүлээгүй тохиолдолд Хувьцаа эзэмшигчээр хэвээр үлдэх саналтайд тооцно.
- 4.6 Энэ журмын 2.2-д заасны дагуу ТУЗ-өөс тогтоосон буюу Компанийн тухай хуулийн 54.5-д заасан хугацаанд Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй буюу хүсэлт гаргаагүй хувьцаа эзэмшигч нь гомдол гаргах эрхгүй байна.
- 4.7 Компани нь хувьцаа эзэмшигчээс 4.4-т заасны дагуу хувьцаа эргүүлэн худалдаж авах шаардлагыг ирүүлсэн тухай бүр саналыг хүлээн авах, эсхүл журмын 3.3-д заасан татгалзах шийдвэрийг гарган хувьцаа эзэмшигчид бичгээр эсхүл цахимаар (Хүсэлтэд заасан цахим болох и-мэйл хаягаар) мэдэгдэнэ.
- 4.8 Компани болон “Таван Богд Капитал УЦК” нь хувьцаа эзэмшигчээс 4.4-т заасны дагуу хувьцаа эргүүлэн худалдаж авах шаардлагыг хүлээн авснаас хойш хувьцаа эзэмшигчийн хүсэлтийг “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” рүү хүргүүлэх бөгөөд хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор шийдвэрлэнэ.
- 4.9 “Таван Богд Холдингс” ХХК-аас энэхүү журмын 2.2-д заасан хугацаанд хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардсан хувьцаа эзэмшигчдийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон хувьцааны үнээр тооцон гаргаж, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь дансанд байршуулна.

ТӨГСӨВ.

“Говь” ХК-ийн хувьцааг худалдан авах шаардах эрхийг
хэрэгжүүлэх журмын Хавсралт №1

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН АВАХЫГ
КОМПАНИАС ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮСЭЛТ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйл, 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрт үүссэн хувьцаа худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа тул “Говь” ХК-ийн ширхэг хувьцааг нэгж үнийг 268.26 төгрөгөөр эргүүлэн авахыг Компанид буюу “Таван Богд Холдингс” ХХК-д зөвшөөрч тухайн хувьцааны мөнгийг авахыг хүсч энэхүү шаардлагыг гаргаж байна.

Хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчийн тухай мэдээлэл¹:

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:

Регистрийн дугаар:

Оршин суугаа хаяг:

Холбоо барих утас

И-Мэйл хаяг:

Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар:

Эзэмшиж буй хувьцааны төрөл тоо, ширхэг:

Гарын үсэг:

Хүсэлт гаргасан огноо:

Компани бөглөх хэсэг:

Хүсэлт хүлээн авагч: “Таван Богд Капитал ҮЦК” ХХК “Говь” ХК

Хүсэлт хүлээн авсан огноо:

Хүсэлт хүлээн авсан ажилтны нэр:

“ҮЦТХТ” бөглөх хэсэг:

Хүсэлт хүлээн авсан огноо:

Хүсэлт хүлээн авсан ажилтны нэр:

Гүйлгээ хийсэн ажилтны нэр:

Хянасан менежер:

¹ Иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргана уу

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 04 сарын 19-ний өдрийн хурлын
19-р тогтоолын 2-р хавсралт



“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Говь” ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч “Таван Богд Холдингс” ХХК-ийн хувьцааны эзэмшил 75 хувийг давсан тул Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр хуралдаж Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасныг үндэслэн бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх шийдвэр гаргаж, тус шийдвэрээр “Таван Богд Холдингс” ХХК-д хувьцаа худалдан авах зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан “ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ” ажиллагааг зохион байгуулж байна.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах тухайд

“Говь” ХК-ийн ТУЗ-өөс эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааны үнийг 268.26 төгрөгөөр тогтоож хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүссэн өдрийг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөр хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигч гаргахаар тус тус тогтоосон.

Хувьцаагаа эргүүлэн худалдах хүсэлтэй эрхэм хувьцаа эзэмшигч та нэгж хувьцаагаа 268.26 төгрөгөөр тооцож компанийд эргүүлэн худалдах бол дараах мэдээллийг ажлын 30 хоногийн дотор буюу 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд “Таван Богд Капитал ҮЦК” ХХК болон “Говь” ХК-д доорх бичиг, баримттайгаа очиж хүсэлтээ гаргах, эсхүл холбогдох маягтыг бөглөн цахим хаягаар ирүүлнэ үү.

Бүрдүүлэх бичиг баримт:

- “Говь” ХК-ийн хувьцааг худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэх журмын Хавсралт №1 буюу “Хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлт”
- Хувьцаа эзэмшигч иргэний тухайд:**
 - Иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл лавлагаа;
- Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд бол:**
 - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
 - Шууд төлөөлөх эрх бүхий этгээд биш бол Итгэмжлэл.

Хүсэлт хүлээн авах хаяг:

№	Хүсэлт хүлээн авагч	Цаасан хэлбэрээр хүлээн авах хаяг	Цахим хэлбэрээр хүлээн авах хаяг	Холбоо барих утас
1	“Таван Богд Капитал ҮЦК” ХХК	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, “Галлериа-Улаанбаатар” худалдаа үйлчилгээний төвийн зүүн жигүүр, 1 давхарт, “Таван Богд Капитал ҮЦК” ХХК	cr@tavanbogdcapital.com.	7272-7282, 94005595
2	“Говь” ХК	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, “Говь” ХК	boardoffice@gobi.mn	94118277, 94995750

Жич: Дээрх хүсэлтийг хувьцаа эзэмшигч нь “Говь” ХК-д гаргаснаар хувьцаа эзэмшигчийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг тухайн хувьцаа эзэмшигчийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд шилжүүлж, хувьцаа эзэмшигчээс хасагдсанд тооцох болно.

Хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааны талаар
асууж тодруулах зүйл, санал хүсэлтээ дээрх хаяг болон утсаар ажлын өдрийн 09:00-18:00 цагийн хооронд холбоо барина уу.